



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮД ХҮНС **1984** ТАНЬ СОНГОЛТ
ОНООС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 он



АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- Компанийн түүхэн товчоо
- Эрхэм зорилго, Үнэт зүйл

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

- 2020 оны зорилт, гүйцэтгэл
- **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- Бизнесийн стратеги
- Зах зээлийн хувь хэмжээ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Хураангуй тойм
- **ТОГТВОРТОЙ БАЙДАЛ**
- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага

ОЛОЛТ АМЖИЛТ


2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



“
**КОМПАНИЙН
ЕРӨНХИЙ ТОЙМ**”



КОМПАНИЙН ТҮҮХ



1984-1999 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ОН ЖИЛҮҮД

1984 он - "Талх чихрийн комбинат" нэртэйгээр ашиглалтад оруулж, хоногт 90тн талх, 5000тн чихэр, жигнэмэг, Өрмөнцөр, 6550тн бялуу, 800тн жимсний чанамал гэх мэт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв.

1999-2004 ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН ОН ЖИЛҮҮД

1999 он - "Талх Чихэр" ХК болон хувьчлагдав.

2003 он - БНСУ-ын Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх хөргүүртэй болон хөргүүргүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Тайван улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэгийн шугам ашиглалтад оруулав.

2004 он - Микробиологи, Химийн лабораторид шинэчлэл хийж, дугуй талх үйлдвэрлэх компьютерийн удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтад оров.

2006-2014 ИНОВАЦИ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОН ЖИЛҮҮД

2006 он - Монгол Улсдаа анх удаа зүссэн талхны хэрэглээг хэрэглэгчдэд нэвтрүүлж, хэрэглээний соёл түгээв.

2008 он - Гурил шүүдайгүйгээр тээвэрлэх тоног төхөөрөмжийг Герман, Украин улсад захиалж, хийлгэв.

2010 он - Нарийн боовны үйлдвэрлэлийн техник технологийг БНЧУ, Голланд улсын иж бүрэн тоног төхөөрөмжөөр шинэчлэв.
- "Та Чи", "Органик" брэндийн зохицуулах үйлчилгээтэй нарийн боов шинээр худалдаанд гаргаж, эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүний хэрэглээний соёлыг түгээв.

2012 он - "Та Чи" 4 төрлийн баяжуулсан талхны урсгал шугам суурилуулав.

2013 он - Улсдаа анх удаа бүрэн автомат талх савлагч төхөөрөмж суурилуулав.

- Дархан, Эрдэнэт хотуудад борлуулалтын баг ажиллуулж, анхны түгээлтээ эхлүүлэв.

2014 он - Чаналгын бүтээгдэхүүний тос шүүгч бүрэн автомат урсгал шугамыг Итали улсын CEPI, CANOL, TECHNO-D ЧЕХ улсын TOPOS фирмүүдэд захиалж, Монгол Улсдаа анх удаа суурилуулав.

2014-ОНООС ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛЫГ ТҮГЭЭЖ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ ОН ЖИЛҮҮД

2014 он - "Фрэнч багет" брэндийг үйлдвэрлэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгон нэвтрүүлэв.

2015 он - Орос технологийн Бородино, сэндвич, бургерийн талхыг үйлдвэрлэж, худалдаанд нэвтрүүлэв.

- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008 олон улсын стандартыг салбартаа анх удаа нэвтрүүлэв.

2016 он - Талх, нарийн боовны үйлдвэрт тус бүр 30.000м² бүрэн автомат агааржуулалтын системийг суурилуулав.

2017 он - Ази тивд анх удаа БНЧУ-ын J4 компанийн хоёр давхар пийшинтэй талхны иж бүрэн урсгал шугам ашиглалтад оруулж, Итали улсын CEPI компаниас 500тн гурил вакум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.

- Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны ISO 22000:2005 олон улсын стандартыг салбартаа анх удаа нэвтрүүлэв.

2018 он - Талх 30 нэр төрөл, нарийн боов 35 нэр төрөл, бялуу болон бэйкери 60 нэр төрөл, жигнэмэг 10 гаруй нэр төрлийг тус тус үйлдвэрлэж,

- Итали улсын CEPI компаниас 500тн гурил вакум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.

- Онцгой брэндийн 6 нэр төрөл бүхий бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, ХХААХҮЯ-ны "Шинэ нэр төрлийн шилдэг бүтээгдэхүүний шагнал"-ын эзэн болов.

2019 он - "Талх чихэр" ХК 35 жилийн босгон дээрээ "Та чи" бэйкери "Хотол" бялууны үйлдвэрийн нээлтээ хийж, 100 гаруй нэр төрлийн бялуу, бэйкери бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэв.

- "Ухаалаг хэрэглэгч" хөтөлбөр хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хэрэглээг дэмжин, хэрэглэгчдэд хэвшүүлж эхлэв.

2020 он - "Martin's Bread" брэндийн талхыг худалдаанд гаргаж эхлэв.

- Орчин үеийн хэрэглэгчдийн чиг хандлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор "Талх Чихэр" ХК болон "Мах Импекс" ХК хамтран "Дэлхийн брэндийг дурсаараа бүтээе" уриатай "Хаан" брэндийн бургер, хотдогны талхыг зах зээлд нэвтрүүлэв.



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРХА ХУНС 1984 ТАНИ СОНГОМ
ОНООС

01

Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

03

Үнэт зүйлс

Т - Тэргүүн технологи

А - Аюулгүй бүтээгдэхүүн

Ч - Чадварлаг ажилтан

И - Итгэлцэл, түншлэл

02


Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

КОМПАНИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦ



Нийт ажилтан
886



Нийт ажилтны 70% орчим нь
40 хүртлэх насны залуучууд
эзлэж байна.

“
**КОМПАНИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОЙМ**
”



2020 оны үйл ажиллагааны тойм

2020 онд **886** ажилтантайгаар **150 гаруй** нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Борлуулалт **63** тэрбум төгрөг буюу өмнөх оныхоос **14,9%** -ийн өсөлттэй байна.

COVID-19 цар тахлын үед ажилчид болон тэдний ар гэрийнхэнд зориулсан нийгмийн халамжийн үйл ажиллагааг үе шаттайгаар хийж хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ ажилчдын дунд “Дархлаажуулалтын хөтөлбөр”, “Хямралыг хамтдаа давцгаая” гэсэн хөтөлбөрийг амжилттай зохион байгуулж, компанийн 800 гаруй ажилтанд нийгмийн халамжийн дэмжлэг үзүүллээ.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, үйлдвэрлэлийн орчин дахь халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээ, ажилчдын эрүүл мэндийн үзлэг шалгалтуудыг тогтмол үе шаттайгаар хийж хэрэгжүүлэн ажилласан байна.

Зах зээл болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, шинэ хэрэглээ, соёл бий болж байгаа учир “Хаан” брэндийн бургер, хотдогын талхыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Мөн хэрэглэгчдэдээ шинэ нэр төрлийн талх, нарийн боовыг танилцуулсан.



2020 оны үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт




ХБНГУ-ын Вернер шугамыг ХБНГУ болон ОХУ-ын технологич инженерүүдтэй хамтран угсралт тохируулга хийж ашиглалтанд оруулсан. Үүний дүнд бүтээгдэхүүний туршилт, технологийн горимыг тогтоон 2020 оны 3 сараас эхлэн Дэлхийн брэндийг дураараа бүтээе уриа бүхий “Khaan” брэндийн бургер, хотдогны 6 нэр төрлийн талхыг үйлдэрлэж, худалдаанд гаргасан нь цар тахал дэгдсэн үед гэртээ хүссэн жор орцыг дагуу хэрэглэх хэрэглээний шинэ хандлагыг бий болгосон.



Технологийн түлхүүр ажилтны тогтвор суурьшилыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд дотооддоо зөвлөх инженерүүдээр сургалт явуулан мэргэжлийн чиглэл олгож, сертификат олгов. Түүнчлэн компанийн хэмжээнд COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, ажилчдын дархлааг дэмжих чиглэлээр 5 үе шат бүхий цогц хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан.



Хөдөө орон нутгийн харилцагч, хэрэглэгч рүү чигэлсэн түгээлтийн суваг тэлэх, орон нутгийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр хөтөлбөр гарган ажиллаж бүтээгдэхүүнийг тодорхой давтамжтай түгээх шинэ суваг бий болгосон. Түүнчлэн COVID-19 цар тахлын улмаас хөл хорнонд байгаа хэрэглэгчидтэй гэрээсээ бараа бүтээгдэхүүн захиалан хүргүүлэн авах боломжийг бүрдүүлэх үүднээс Etachi.mn вэб сайт нээн ажиллуулж, амьдралын шинэ хэв маяг руу шилжин ажиллах цахим хүргэлт, түгээлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн.



“
**БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА**
”



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



БИЗНЕС ПРОЦЕССИЙН БАРИМТЛАХ СТРАТЕГИ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГИНЖИН
ХОЛБОО УДИРДАГЫН СТРАТЕГИ



Үйл ажиллагааны гинжин хэлхээг оновчтой байдлаар ажлуулахын тулд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалт, түгээлт болон харилцагч нарт хяналт тавих бодлого баримтлан ажиллах



ХЭРЭГЛЭГЧ БА МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ



ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ,
БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлээд зарах бус, дата мэдээлэл, ажиглалт судалгаан дээр тулгуурлан хэрэглэгчдийн чиг хандлагад тулгуурлан сэтгэл ханамжийг тэргүүнд тавин ажиллах



“Талх Чихэр” ХК болон “Мах импэкс”
ХК-ийн хамтарсан анхны брэндийг зах
зээлд танилцуулж хэрэглэгч
үйлчлүүлэгчид хоногшуулж чадсан юм.
2020 оны 3 сард худалдаанд гарсан.



Шинэ бүтээгдэхүүн



Martin's bread

ЧИАБАТТА
КАЙЗЕР РОЛЛ
АМЬД ХӨРӨНГИЙН ТАЛХ



“Та Чи” брэндийн
нарийн боов

СҮҮТЭЙ МӨӨХИЙ




“Онцгой” брэндийн
нарийн боов

АРВАЙН ШАНЗТАЙ ЕЭВЭН
ШАР ТОСТОЙ ЕЭВЭН
АМТАТ ЖИГНЭМЭГ
БҮХЭЛ ҮРИЙН ЗӨГИЙН
БАЛТ



Кето бүтээгдэхүүн

КЕТО ТАЛХ
МААЛИНГЫН ГУРИЛТАЙ
ТАЛХ
ВЕГАН ХАГУУ ТАЛХ
АЛМОНД КОКОСНЫ
ГУРИЛТАЙ ТАЛХ



Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, шинэ хэрэглээ, соёл бий болж байгаа учир бүтээгдэхүүний нэр төрөл болон тоног төхөөрөмж нэмэх шаардлага бий болсон.

Иймээс ХБНГУ-ын бургер, хотдогны талхны шугамыг үйлдвэрлэлд суурилуулж, “Хаан” брэндийг дотоодын зах зээлд амжилттай нэвтрүүлж, хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Мөн MIMAC хэвлэгээний машиныг ашиглалтанд орлуулан уламжлалт шар тос, өрөм цөцгий, бурамны шанзтай еэвэн үйлдвэрлэн хэрэглэгчдэд амжилттай таниулж чадсан .

Байгууллагын хэмжээнд цаашид ашиглагдах боломжгүй техник, тоног төхөөрөмж, борлуулалтад ашиглагдаж байсан элэгдэж, муудсан авто машин зэргийг актлан ТУЗ-ийн шийдвэрийн дагуу худалдан борлуулж, Автопарк-д БНСУ-аас Hyundai Porter, Kia Bongo маркийн автомашины шинэчлэл хийсэн.

Бялуу, нандин бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд “Хотол” бялууны үйлдвэрт COPY CASE буюу хэвлэлттэй бялууны принтер шинээр суурилуулж, дугуй бялуун дээр хэрэглэгчдийн хүссэн зургийг, хүссэн загвар дизайнаар хэвлэж, хүргэх боломжтой болсон байна. Мөн бялуун бүтээгдэхүүний зах зээлд өөрсдийн байр сууриа бататгахын тулд менежментийн ажлуудыг шат дараалалтай хийж, нийгмийн хариуцлагын хүрээнд COVID-19 цар тахлын үед ажиллаж байгаа онцгой, цагдаа, ХӨСҮТ, дотоодын цэрэг гэх мэт төрийн албан хаагч нарт талархал илэрхийлэх аяныг “Талархлын бялуу” нэртэйгээр амжилттай зохион байгууллаа.

ISO 9001:2015, ISO 22000:2005, ISO/IEC17025:2007 стандартын шаардлагыг хангах зорилгоор засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэхээс гадна аюулгүй чанартай бүтээгдэхүүн хэрэглэгчийн гарт хүргэхийн тулд металл илрүүлэгч төхөөрөмжөө сайжруулан шинэчлсэн. Мөн COVID-19 цар тахалтай холбоотойгоор Гурвалсан үйлчилгээтэй халдваргүйжүүлэх хаалга, Мананцар үүсгэн шүршигч Автомашин халдваргүйжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан өндөржүүлсэн бэлэн байдлын дор ажиллаж байна.

“ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН ”



2020 ОНЫ САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТОЙМ

НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

63,054,200,000

УЛСАД ТӨЛСӨН ТАТВАР

447,200,000

Компани 2020 онд **63,054,2** сая төгрөгийн борлуулалт хийж, урьд оноос орлого **8,198,4** сая төгрөгөөр буюу 14,9%-иар өссөн. Тайлант онд ашигт ажиллагааны түвшин урьд оноос 1,1-ээр буюу өсөлтийн коэффициент 1,4 хувиар өссөн нь чанарын үзүүлэлт юм.

2020 он бүхэлдээ цар тахалын хүндрэлтэй үед зардлыг зохих түвшинд барьж, орлогоо нэмэгдүүлж ажилласан амжилтай ажиллаа.



“
**ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ**

”





ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Нийгмийн халамж

Ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс

✓ Дархлаагаа дэмжээрэй хөтөлбөр:

- Энэ хөтөлбөр нь 5 үе шаттай явагдсан. Витамин C,D бүтээгдэхүүний дээж, бэлэн мөнгө, маск санитас гэх мэт зүйл өгсөн
- Ажлын байрны ариутгал, хадваргүйжүүлэлтийг тогтмол хийсэн.
- Ажилчдын дунд “Талархал-Бахархал” аян өрнүүлсэн.

✓ Ажлын байрны цомготгол хийлгүй ажлын байрыг нэмэгдүүлсэн.

Сургалт, хөгжүүлэлт

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Сургалтанд нийт 200 гаруй ажилчид хамрагдсан

- ✓ Борлуулалтын албаны борлуулагч менежерт ур чадвар олгох сургалт
- ✓ Дотооддоо зөвлөх инженерүүдээр сургалт явуулан мэргэжлийн чиглэл олгож, сертификат олгосон
- ✓ Шинэ ажилтаны сургалт
- ✓ Ковид 19-н мэдээлэл, сургалт



С. Номιο
31 Dec 2020 · 📷

darkhlaa demjix ayn 🍪🍪🍪 xeregtei vyde bx ezendee ochsoon 😊😊 bidniigee demjij ajillaj bga udirlaguudda talarxaj bga ba ulam ilvv xicheej ajillanaa 🍪 shine onii mend 2021 🎉🎊🎊



👍👍 Battur Lkh and 20 others 2 comments



11:29 📷

👍👍👍 Tami Sumiyadorj and 70 others 29 comments

👍 Like 💬 Comment 📧 Send

С. Номιο is with **Tsend-Ayush Purevjamts.**
10 Feb · 📷



👍👍👍 70 25 comments

👍 Like 💬 Comment 📧 Send




Jantsan Naraa
26 Jan · 📷



👍👍👍 Narantsetseg Lkhamjav and 79 others 33 comments

👍 Like 💬 Comment 📧 Send

Баатад Өлзийсайхан Болдбаатар
26 Jan · 📷



11:32 📷

👍👍👍 **Altangerel Dalaidulam**
31 Dec 2020 · 📷

Талх чихэр ххк баярлалаа 🍪🍪 Нийт ажилчид хамт олондоо ажлын өндөр амжилт хусье. Шинэ оны мэнд хүргэе 🍷 Сайхан баярлаарай 🍪🍪🍪



👍👍👍 Narantsetseg Lkhamjav and 7 others 1 Comment

👍 Like 💬 Comment 📧 Send

COVID-19 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дэлхийн хэмжээний цар тахал COVID-19-ийн үед “Талх Чихэр” ХК-ийн хамт олон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хийж хэрэгжүүлэн өндөржүүлсэн байдал дор ажилласан.

- Борлуулалтын машины ариутгал тогтмол хийж түр цэгээр дамжуулан үйлдвэрээс гарах болон орох хөдөлгөөнийг байнга хянаж байна.
- Нийт ажилчдад тогтмол амны хаалт тарааж амны хаалт зүүх, солих, ашиглах хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, ажилд гарах үед халууныг шалгаж үзээд ажилд нь оруулж байна.
- Компанийн хэмжээний ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж гурвалсан үйлчилгээтэй халдваргүйжүүлэх хаалга суурилуулсан.
- Тухай бүр тушаал холбогдох дүрэм журам гарган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

